

ӨГҮҮЛЭЛҮҮД

Д. Сүхбаатарын төрсний 95,
наснаас нөгчсөний 65 жилийн ойд

СҮХБААТАРЫН ҮЗЭЛ САНААНЫ
ӨВ, ШИНЭ СЭТГЭЛГЭЭ

(НИЙТЛЭЛ)

Д. МААМ

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

1. Цагт төрж, цагийг төрүүлсэн хүний хөрөг

Сүхбаатар төрсөн. Сүхбаатар наснаас нөгчсөн. Гэвч Сүхбаатар үхээгүй. Тэр хүнийг үхүүлээгүй үүрд оршихын мөнхийн ус нь их үйлс, хиргүй ариун үзэл санааны нь өв болж ирлээ. Цэлмэг тэнгэрээс буун орж ирэх цасан хялмаа мэт хойшдын олон гэгээн он жилүүдэд ч тийм байсаар байх болно...

Зуу шахам жилийн тэртээ аж. Цэцэнхан аймгийн Гадин засгийн хошууны Мандал хэмээх бяцхан хийдийн байрлах ботгон толгодын дэрст хөндийгөөс хорин хэд, гуч эргэм насны залуу эр эм хоёр түлхүү сайнаар аж төрөх горил өвөрлөсөөр ганц цагаан мориндоо ууган хүү Дэндэвийг унтуулж, бага хүү Ранжингаа араганд хийж үүрээд Богдын Хүрээг тэмцэж цагаачилан хөдөлжээ. Эд бол хэдхэн жилийн дараа Сүхбаатарын эцэг болох Дамдин, эх болох Ханд нар, тэдний нутаг орноосоо дайжиж зугтсан тухай дээрх бяцхан зураглал бол тэр цагийн Монгол орны жирийн хүн ардын амьдрал ахуйн ерийн явдал, хэв шинжит дүр төрх байлаа.

Залуу хос хоёр хүүхэд, яндан цагаан морины хамт яван явсаар Хүрээний шадар хороолол Амгаланбаатарт ирж суурьшсан байна. Анги давхарга нэгт хар борчууд хатавч туурга, өрх тооно, дээвэр бүрээсий нь нэг нэгээр цуглуулсаар умгар хар овоохой бүрдэж, барлаг Дамдин гүймэл цагаачдын оромжлох Хэрмэлийн жисаа тус газар ханыхаа шийрийг хатгаж, Ханд голомты нь бадраасан тэр айлд Сүхбаатар хүү мэндэлснээс хойш өдөр хоног ульжин холдсоор эдүгээ ерэн дөрвөн жилийн босго халагдаж, ерэн тав дахь жилийн босго нээгдлээ.

Дөрвөн ханатай тэр умгар овоохойн одоогоор дархлагдаад буй томгот буурины дэргэд очиж зогсоход юу эс бодогддог билээ. Дуунд орох хувьтай Сүхбаатар энд эхээс тасарч уйлсан. Их юм бага юмнаас, хорвоогийн хүмүүн болгоны заавал дамжих, заавал давтагдах энгийн юмнаас эхэлдэг нь үнэмлэхүй үнэн ажээ гэж бодно. Мөрөө энд, энэ л буурин дээр анх гаргаад нэрээ мөнхөлсөөр үнэн цагаан үйлсийн хязгааргүй өөд Сүхбаатар биднээс хол тасарч одсон байна гэж бодно. Мэргэн ардынхаа хэлэлцдэгээр «тэнгэрээс од шүүрсэн» тэр хүн тухайн орчин цаг, одоо цагаас тийнхүү хол илүү давсан ч бидний дунд шатаж буцалсаар, «...гагцхүү сэтгэлийн чин зориг мэднэ. Ташаагүй үнэн болохыг би батлан хэлнэ»-хэмээн тунхагласаар явнаа гэж

бодно. Бас манай уужим дэлгэр нутагт Сүхбаатарыг тосож авсан энэ алгын чинээ газар шиг Монголын сэтгэл зүрхэнд илүү ариумсаг, илүү тэнгэрлэг, илүү шүтээнлэг булан тохой өөр бийсэн үү, үгүйсэн үү гэж бодно. Хөл алдаж, хөл олсоор бодол үргэлжилнэ. Их хүний тухай бодол их хүнтэйгээ адил их болохыг би ойлгоно.

Нас шүд нь хэдэн мянган жилээр хэлэлцэгдэх, нүүдэлчдийн соёл иргэншлийн нэхий өлгий, Төв Азийн өвөг агаад цэл залуу үндэстэн Монголын түүхэнд зуун жил ер юухан байх ажээ. Гэвч энэ зуун жил шинэ Монгол, социалист Монгол улс төгс бүрэлдэн тогтохын цаг тоо ны бичгийг өөртөө агуулснаараа өмнө хожид ижилгүй он жилийн түүхэн сондор болж байна. Сүхбаатар энэ зуун жилд багтаж төрөөд, энэ зуунаасаа хальж гарчээ. **Тэрвээр цагаас төрсөн, цагийн хүү аж.** Юу гэвэл Богд хаант Монгол улсын үүсгэл, Хятадын эзэрхэг цэргийг цагаан хэрмийн хормой хүртэл Монгол эрс шил даран хөөсөн таван замын байлдаан, эх орны тусгаар тогтнол том гүрнүүдийн улс төрийн инжидлэгэнд хэлмэгдэн, сэрэхийн зуурт алга болдог зүүд мэт Хятадын харьяат «Ар Монголын автономит» гэгч төдийд хувирч хяхагдан жижгэрсэн төрийн эмгэнэлт явдал, гэтэл шингэсэн нар баруун хойноос эргэж гарахын адил цагаан хааны ширээг хөмөрсөн оросын Октябрийн дуулиан зэрэг гэрэлтэй, сүүдэртэй бас гэрэлтэй их хэрэг явдлуудын босгонд заримд нь оролцох зэргээр Сүхбаатар тэр цагаас төрж, тэр цагийн хүү нь болсоор бие тэгшрэн өндийсөн юм. Угаас сэргэлэн, Голч шударгуу, ядуу барлаг идэрхэн Сүхбаатар «өдөр түлхэн өсөж» эрийн цээнд хүрсэн хүрээгүйн заагт явахдаа түүхийн совин, эх оронч бахархал, ангийн мэдрэхүй, улс төрийн сэтгэлгээний юм юмтай болж, ягуу ягуухнаар хатамж суун, улмаар зовсон ардын үнэн хэргийн төлөө ганц үзүүрт сэтгэл шуударсныг үйл хэрэг нь хувьсгалын үйл хэрэгтэй найран амьссан тэр хүний яруу түүхэн замнал батламжилан хэлж байна. **Тэрвээр цагийг бүтээсэн, цагийн эзэн хүн аж.** Юу гэвээс Сүхбаатар ардын журамт цэргийг эмхэлж, ардын намыг байгуулалцаж, ардын хувьсгалын магнайд явж, их Октябьтай ардын ёсны найрамдлыг үндэслэлцсэн. Үүгээр хуучны босго халагдаж, ардаар овоглосон шинэ цаг тодорсон бөгөөд бүхний тэргүүнд явж энэ цагийг бүтээсэн Сүхбаатар энэ цагийн эзэн болж мөнхөрчээ. Одоо ардаар овоглосон хүн бишгүй олон байна. Гэвч Сүхбаатартай эн зэрэг цэх юм уу, түүнд өчүүхэн ч болов дөхөж «Монгол ардын. . .» хэмээн хэлүүлэх тийм эрх дархны хүн ер үгүй билээ. Энэ бол бас ч бодож тогтоовол зохих зүйлийн нэг. Баримт сэлтийг улируулан судалж ажиглахад алив аугаа ихийн хууль ёсоор Сүхбаатар аугаа их даруу хүн байсан нь ой ухаанд ургаж буудаг. Тэрвээр гавьяагаа мэддэг байсан ч мэддэгээ мэдэгдэхгүй явжээ. Зарим хүн түүний хүрэлцээгүй ядуу амьдралыг «тэтгэх» томмол бодлоор нам төрийн нэр барьж шан харамж хүртээх хэмээхэд Сүхбаатар танигдахын аргагүй эрс дошгин болж хувираад мөнгө хишиг горилж нийтийн хэргийн төлөө зүтгэсэнгүй билээ би хэмээн хатуурхсан тухай түүхэнд өгүүлсэн байдаг.

Сүхбаатарт ганцхан үнэн байлаа. Тэрвээр 1919 онд Данзан, Догсом Дугаржав нартай төрийн улаан ордны, их хүчийг бэлэгдэл болгосон арслангийн чимэгт дааман хаалганы өмнө үүр шөнийн заагт болзол уулзаж эрхий хурууныхаа цусыг шимэлцэн «үгээгүй доордын хэргийн төлөө үхэх амийг үл хайрлана» хэмээн гэгээн андгай өргөж, анхны

нууц дугуйланг үндэслэлцжээ. Түүний ганц үнэн нь энэ андгай байсан бөгөөд тангарагийг ганцхан удаа өргөдгийн үнэмшилтэй жишээ дууриалал нь Сүхбаатар өөрөө явлаа.

Тэр хүн амьдралынхаа хамгийн хүнд хэцүү мөчид зөвхөн ард түмэнтэйгээ ярилцдаг байв. Нэгэн удаад Хиагтыг алдаж мэдэх түгшүүртэй үед Сүхбаатар:

—Би ард түмэндээ огтхон ч хар буруу санаж яваагүй!... Амь бие даанч ганцад харамсана. Гэвч үхтэл тулалдана-гэж нөхөддөө хэлж байсан аж. Ийм жанжинтай журамт цэрэгт ялахын од байснаас ялагдахын учир байгаагүй бөгөөд чингээд ч тэр жанжин, тэр журамт цэрэг, ардаар овоглосон нам гурав хувьсгалын гал голомтыг цогцлуулсан тулгын гурван чулуу нь болсон юм.

Сүхбаатар Монголыгоо жинхэнэ ёсоор хайрладаг, Монголоороо жинхэнэ ёсоор бахархдаг хүн явав. Ийм байж чадсан учраас тэр хүн нэгэн үе том яваад түүхийн өгтөөнд айхтар дарагдаж, тэгснээ дахин төрсөн шинэ Монголын гэгээн цуу, үгүйрэшгүй бадрахын бэлэг дэмбэрэл байж билээ. Ийм байж чадсан учраас тэр хүн бүх Монголын хайрыг татаж, бүх Монголын бахархал болсон юм. Баруун Монголын Парчин хуурч «Халхад Сүхбаатар гэдэг хүү төрсөн гэнэ. Домборын арьс, хурууны хээ хоёроо элэгдтэл тууль хайлсан өвгөн Парчины санаа сая бүтэв. Үхэхэд гомдолгүй!» гэж хөөрсөн гэдэг.

Өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болшгүй соёл

Үхтэл орших төрөлх нутаг салж болшгүй орон-гэсэн найргийн мөрүүдийг Сүхбаатар амжиж сонсоогүй ээ. Гэвч энэ тэнгэрлэг ариун найргийг бүтээх Дашдоржийн Нацагдоржийг Сүхбаатар таньж, өөрийн нарийн бичгийн даргаар ажиллуулж байлаа. Гэтэл Сүхбаатараас хойш Нацагдоржоор наранд биш нарсанд шүлэг бичүүлсэн үе бий! ..

Эзэнт гүрний «хөрст дэлхийг хөрвүүлсэн» их илдийн үе, бага хаадын харилцан уулгалаан, Манжийн дарангуйллын өмнө сөхөрсөн эмгэнэлт явдал, олон сайн юмыг «нүгэл» гэдэг ганцхан үгээр цаазалсан шашны наминчлал эд бүхэн нийлж Монголын нийгэмд айдас, аймшиглахын зузаан хөр, мөсөн уулыг тогтоосон байлаа. Сүхбаатарыг «аймшиггүй Чин зоригт Сүхбаатар»-гэж нэрэлдгээс, түүнд ардын төрөөс «Зоригт баатар» цол шагнаснаас ургуулан бодохуй нэгэн утгаар манай хувьсгал бол айдасын мөсийг ханз татаж, түүний эсрэг түүнийг сөрж гарч ирсэн хувьсгал юм. Хувьсгалт дайчин уламжлалын амьд бие бүрэлдэхүүн болж төлөвшсөн ил тодоор шүүн хэлэлцэх сүхбаатарч зарчим, айхын дарамт бус, хүндэтгэл бүхий ардчилал нь баруун зүүний завхрал, 30 аад оны хэлмэгдэл, ганц хүнийг тахин шүтэхийн хор хөнөгөөл, түүний дараахь хэлбэрдлэгийн олон жилийн турш нэгэн үе мартагнан орхигдож, цаг хүйтэрснийг эргэж бодоход гэгээн үйлс, аймшиггүй агаад ардач үзэл санаагаа үлдээсэн ч өөрөө алга болсон Сүхбаатараараа манай хэрэг, манай ард түмэн өнчирч байсан цаг бий гэж санагдана.

Ядуу ангийн төгс билгүүн мэдрэхүйгээрээ Сүхбаатар их Ленин, Зөвлөлт оросын үнэнг ойлгосон хүн байв. Хоёр ард түмний нөхөрлөлийг цаг зуурын цэргийн холбоо төдий биш бүхэл бүтэн эриний шударгуу цагаан үйлс гэж Сүхбаатар хэлж сургаж байлаа. Тэрвээр нэг удаа дэг сахилга алдсан орос цэргийн дарга нарыг дуудан ирүүлж Монголд илгээсэн Зөвлөлт засаг Лениний даалгаврыг омсгойтлоо хэмээн зэмлэж, Октябрийн орны хуулиар шийтгэхийг сануулж байсан байна. Зөв-

хөн ганц энэ жишээнээс Сүхбаатарын хувьд Монгол-Зөвлөлтийн найрамдал нь уриа лоозон, хундаганы үг, талархал ёслолын иш татлага төдий биш, байнга бүтээлчээр хандах ёстой цогц том үйл хэрэг байж гэдэг ойлгогдоно.

Монголын бахархал, Монгол эх оронч үзэл, Монгол-Зөвлөлтийн найрамдалд чухам хуурмаггүй чин үнэнч чанар, улс төр дахь хувийн явдлыг таслан зогсоох зарчмаас Сүхбаатарын ертөнцийг үзэх бодь үзэл, интернационалч ёс суртахуун төлөвшин тогтжээ. Түүний бие яах аргагүй Монголын хамгийн анхны, хамгийн шилдэг коммунист юмдаа гэсэн бодол энэхүү нийтлэлийг бичих явцад сэтгэлд байн байн орж ирж байлаа.

2. Цаг цагийн холбоосын тухай бодол

«Үнэн» сонин энэ оны 2-р сарын 2-ны дугаартаа «Сүхбаатарын зарчим» нэртэй өгүүлэл нийтэлжээ. Удирдагчийн сэрүүн тунгалаг ахуйд «зарчим» гэдэг үгийг хэрэглэдэггүй байв. «Зарчим» гэдэг үгийг хэрэглэдэг болсноос хойш гайхалтай агаад харамсалтай нь «Сүхбаатарын зарчим» гэж ярьж хэлж заншилгүйгээр нэг л мэдэхнээ өдийг хүрсэн аж. Гэтэл Сүхбаатар зарчмын дээд зарчимтай, хүний туйл, манай бахархал болсон хүн явсан билээ. Сүхбаатарын зарчим нам, ардын төр маань үндэслэлцсэн бөгөөд одоо ч амьд бүтээлч үйл хэрэг хэвээрээ байна. Ийм бодолд хүргэж байгаад дээрх тэргүүн өгүүллийн шинэлэг сэтгэлгээ, ургуулан бодуулахын өгөөж, ашигтай үр оршиж байгаа юм.

Зарим хүнд улирсан мэт санагдах, заримых нь тухайд огт мартагдсан боловч ер тиймгүй, харин ч уламжлагдан өрнөсөөр байх ёстой, уламжлагдан өрнөх ч хувьсгалын анхны аугаа их жилүүдийн хэрэг явдал, Монголоо хэмээсэн эх оронч бахархал, хувьсгалт дайчин үйлсийг өнөөдрийн шинэчлэлт, өөрчлөн байгуулалтын үзэл бодлын үүднэ авч үзэж, цагийн хэлхээ холбоог сануулах гэсэн оролдлого, эршүүд зоримог санаа «Үнэн» сонины хуудаснаас ажиглагдаж байв. Энэ сайн хэргээ.

«Нам улсыг үндэслэн байгуулагчийнхаа мэндэлсэн өдрийг дурсах бүрийд бид бүхэн ..., түүний эрхэм шинжийг хадгалж байгаа эсэхээ шалгаж үздэг» - гэж сонин бичжээ. «Зөвхөн ойгоор нь л уу?», «үнэхээр бид бүхэн гэж үү?», «ердөө л шалгаж үзэх төдийхнөөр асуудал төгсөх үү?» гэх мэт олон асуултыг сэтгэл дундуур хэрсүү уншигч гаргаж болноо. Гэвч дээрх өгүүлэл хэдийгээр барьж тавьсан мөчидхөн шинжтэй, бас цацагдсан байдалтай, тун ерөнхий мэт боловч чухал нэгэн санааг айхтар онож хөндөж товойлгосноороо олзуурхалтай байна. Үнэхээр бид чинь өөрсдөө чухам сүхбаатарчууд мөн үү, нэгэн зэрэг бидний хэрэг түүний үйл хэрэг, ширгэшгүй ундрагатай хувьсгалын маань хэргийн холбирултгүй амьд бүтээлч үргэлжлэл байсаар байж чада уу гэдэг асуулт эндээс урган гарч ирж байгаа юм. Бодол бясалгалын үр хөврөл болж «Үнэн» сонины чухам онож дэвшүүлсэн асуудлын цөм энд байна. Цагийн хэлхээ холбоо тасрах аюул байгаагүй ч, нарийсан бүдгэрсэн явдал байсныг Сүхбаатарын зарчим, ил тодын зарчмаар сөхөн хэлэлцэх цаг нэгэнт тулж иржээ. Ил тод, ардчилалын зарчим чухамдаа Сүхбаатарын зарчим юм. Монголын ард түмэн, ардын хувьсгалын түүхэнд Сүхбаатарын үлдээсэн эрхэм дууриаллын дардан зам

зуун намрын бороо, зуун хаврын хавсарганд ч улбааран бүдгэрэх, өвс шарилжинд идэгдэх тийм нэгээхэн цагийн мөр биш байлаа. ..

В. И. Ленин Марксын зохиолыг уншиж судлахаа «Маркстай ярьж зөвлөх» гэдэг байв. Нэг хүнийг тахин шүтэхийн үед Сүхбаатартай «ярьж зөвлөх» явдал хэрэг дээрээ үгүй болсон. Гэвч энэ бол Дээд газраас тухайлсан шийдвэр гарч, олноор тунгаан хэлэлцэх манай түүхийн эмзэг хөндүүр, бэрхшээлтэй ээдрээтэй зурвас урт ужиг үеийн томоохон асуудал учир бид энд хөндсөн төдийгөөр орхиоос өөр аргагүй. Ийм болохоор өөрсдийгөө, одоогоо Сүхбаатартай холбож харьцуулж хэдхэн зүйл жишээн дээр товч авч үзье.

Д. Сүхбаатар, бүх цэргийн жанжины хувьд түүний удирдлагын дор ажиллаж байсан. Сурган боловсруулах хэлтсийн ажлыг сайжруулахын тул «...удаа бүр зүйл дараалан илтгэн ухуулж хэлсэнд» дургүйцсэн хүмүүс «битүүлгээр заалдан тэмцэж» мэдүүлснийг эрс буруушаан засгийн газарт бичиг өргөж «зүйл дараалан байцаан тодорхойлж, тогтоосон дүрэм ёсыг илтгэн, хойчийн сайн замыг нээгдүүлэн, таавар гэмийг ариутган гүйцэтгэхийг» хүсэж илгээсэн баримт бичиг байдаг билээ. Их жанжины хүсэлтийг дээд газар анхааралтай хянан үзэж буруутай этгээдүүдийн явдлыг газар авахуулалгүй нэгэн мөр болгож заагласан аж. Энэ бол тухайн асуудлыг ардчилал, төвлөн удирдах ёсны зохицоллын үндсэн дээр зарчимтайгаар шийдвэрлэсэн шилдэг жишээний нэг юм. Алслан холдсон ч ойр хэвээр байгаа тэр цагт их удирдагчаар минь хүртэл гоочилж оролдож байсан тэр хүмүүстэй цусны бүлэг нэгтэнгүүд одоо ч байсаар байна. Бид тэр болгоны замыг Сүхбаатар шигээ хөдөлбөргүйгээр таслан зогсоож чадаж байна уу, үгүй юу?! Энэ ч бас л нэг асуудал. Хуулийн байгууллага, захиргааны олон шат нэгж дээр ирсэн нэртэй нэргүй бичиг захидлыг хав дарах юм уу, задалж шийдвэрлэхдээ хэн бичсэн вэ гэдгийг анхаарахгүй, хэний тухай бичиж вэ гэдгийг голчлон анхаарч, өглөөхөн ярьсан ил тодын зарчмаа өдөр дунд мартаж, ардчилалыг умартуулж, шударгыг хэлмэгдүүлж, үнэн ба хариуцлагыг омсгойтож байгаа явдал бишгүй л гардаг.

Сүхбаатарын ойг тэмдэглэх ёслолд сайн дурын уран сайханчдыг дуу дуулуулж, хуур хуурдуулах нэрийдлээр туслах төлчдийг хөдөө явуулаагүйгээс болж төлийн их гарздал гаргасан тухай санчигийн цагаан хялгасаа илбэн байж нэгэн буурал хүүрнэж билээ. Тэр ярианы үеэр би Сүхбаатар амьд сэрүүн цагтаа хувьсгалын баатарлаг туульс дуунаас:

Ухаа хонгор морьтой доо

Улсын их л жанжиндаа

Учир бүгдийг ухуулсан

Ухаан ихтэй л хүндээ - гэсэн өөрийн тухай дөрвөн шад шүлгийг хасуулах санал тавьж дээш өргөн мэдүүлж байсан гүн зарчимч, төв шударгуу, энгүүн даруу хирнээ хувийн дотоод сэтгэлийн гайхалтай баатарлаг явдлыг партизануудын амнаас олж сонссоноо өөрийн эрхгүй эргэж санасан, Сүхбаатар маань тийм л хүн байв. Гэвч харамсалтай нь тэр хүн эрт одож, амьддаа хөшөө босгуулах тахин шүтлэгийн үе эрт эхэлжээ.

Шууд хэлэхэд Сүхбаатарын үзэл санааны ард түмнийхээ сайн сайхны төлөө юугаа ч эс хайрлах цорын ганц голч зарчим бүхий ариун тансаг их өвийг бидний үед ч омсгойтсоор ирж шүү дээ. Бараг дарга нэртэй болгоны суудлын арын хананд Сүхбаатарын хөргийг нямбайлан

хадаж тогтоосныг харж болно. Гэтэл олон дарга, мөн Сүхбаатар коммунист хүн явжээ гэж хэзээ ч бодож тогтоож үзээгүй байж «коммунист»-гэдэг үлэмжийн учир утгатай нэрээр өөрийгөө өргөмжлөх дуртай бүр олон хүмүүс жинхэнэ сүхбаатарч ёсоор ажиллаж амьдарч чадахгүй байгааг бас харж болно биш үү. Сүхбаатарыг зурагт хуудасчилах, хөрөгчилөх, түүний үзэл санаа, соён гийгүүлэх дууриалалаас суралцах явдлыг хялбарчлах хандлага газар авчээ! Сүхбаатартай уулзаагүй хүн уулзсан болж ярих, хэлээгүй үгий нь хэлсэн болгож «дурдатгалах» төрөл ургийн хамаагүй байж хамаатсах зэргээр «сайн хүний нэрийг өөрөө гурав худалдаж, ач зээдээ үлдээх» гэдгийн үлгэрээр орчихсон явдлуудын талаар энд өгүүлэх нь ч илүүц биш л болов уу!

Бидний хэдэн нөхөд хуучин сэтгэлгээ, шинэ сэтгэлгээний талаар ярьж маргалдаж байлаа. Нэг маань над руу хандаж: «Чи жанжины тухай ном бичиж байгаа хүн гэсэн. Энэ асуудал чиний толгойг их л ядраасан байж таарна. Саналыг чинь сонсьё!» гэдэг байна. Гэтэл хоёр дахь нөхөр шинэ хуучин сэтгэлгээнд Сүхбаатар огт хамаагүй гэсэнэрхүү санаа хэлэв.

Би тэгэхэд нь гар эхээр байгаа номноосоо иш татаж: «Сүхбаатарын богинохон амьдралын яруу түүхэн замнал бол тэр чигээрээ хувьсгалч шинэ сэтгэлгээ, түүнийгээ ажил амьдрал болгохын төлөө амь хайрлаагүй тэмцэл, ажил амьдрал болгосон их үнэн, ялгуусан дууриалал билээ. Чухамдаа шинэ сэтгэлгээ бол мартагдсан сүхбаатарч сэтгэлгээ юм-гэж хариулсансан. Тэгэхэд нөгөөх хоёр дахь нөхөр тийм ч байж болох, үгүй ч байж мэдэх юм» гэсхийгээд сууж байв. Энэ бол хамгийн наад зах нь үхээнц дорой амьд дайчин биш явдал болов уу. Улс орны социалист өөрчлөн байгуулалтын үеийн шил шилээ даран босч ирж байгаа түг түмэн асуудлыг шийдвэрлэх тулгам хариуцлагатай өнөө үед иймэрхүү «тийм ч биз, үгүй ч биз» гэх ганганаас цаашгүй бүдүүвч зураг, ацан ойлголт байж таарах уу даа гэж бодогдоно. Хувьсгалч дайчин уламжлалаас холдоорхож, сүхбаатарч зарчмыг мартагдан, улс төрийн ноён нуруу суугаагүйн гэрч болох иймэрхүү бүдүүвч сэтгэлгээтэй, чухам хэлбэл ерөөс сэтгэлгээгүй байгууллагын дарга, орлогч зэрэг хичнээн олон хүн машин хүлэглэж, жолооч хэрэглэсэн чухал чухал ажил албанд сууж байдгийг төсөөлөн бодохуй сүхбаатарч зарчмын үүлнээс хүржигнэн буух өөрчлөн байгуулалтын ариутган цэвэрлэх хур ямар шиг их үгүйлэгднэм билээ! Сүхбаатарын тухайд ихэнхи тохиолдолд унасан хүлэгний нь 300 бичгийн ширээ нь, Сэлэнгийн сав дахь олон харуул, хэдэн арав хориор тоочих айлын хот, нийслэл хүрээний гудамж талбай албан тасалгаа нь, хөдөлмөрчин олон, ардын журамт цэрэг хуралдагсад нь байлаа. Оршуулах ёслолд нь оролцсон зөвлөлтийн элчин сайдын үгээр «морин дээр ядуу төрж, ядуу хэвээр хүлгийн зоон дээр өөд болсон» тэр хүн өөрийн бие сэтгэлд хүнд суртлын тоосыг ч халдаахгүй хэмээсэн хатуу зарчимтай явжээ. Түүний үзэл бодолд хүнд суртал хэмээх гай гал усны адил харш байсан аж.

Дайсныг таньж чухамаас жигшиж чаддаг, нөхрийг таньж чухамаас нөхөрлөж чаддаг, цэл залуу гучин настайгаар Монголын сэтгэл зүрхэнд мөнх оршсон тэр хүний улс төрийн ленинч хат, ард түмний жаргалын цэнхэр одыг олж үзсэн билгүүн хараа, ангийн мэдрэхүй нь тэр үедээ ч, хойчийн өдрүүдэд ч эгнэх жишээлэх хосгүй билээ. Үүн дээр Сүхбаатар нь манай ард түмний оюун ухаан, эрэлхэг зориг, нөр хөдөлмөрч, энгүүн хавархаг, бичиг соёлын онч мэргэн зэрэг чанарыг төгс өвчиж,

ээгнэнхэн төрсөн хүн гэдгийг нэмэн хэлэх учиртай. Энэ бүхий чанараараа ардын хувьсгалын удирдагч байн байсаар байх тэр хүн Монголчуудын үндэсний бахархалын цогц бүрдэл, товчоо цомнол болж явна.

Цагт төрж, цагийг төрүүлсэн хүний хөрөг, цагийн холбоосын тухай анхны бодол ийм байна. Бодол үргэлжилсээр ...

ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ДЭВШИЛ, БНМАУ ДАХЬ СОЦИАЛИСТ БАЙГУУЛАЛТ

Г. СҮРЭНЖАВ

Философийн ухааны дэд эрдэмтэн

Манай эрин үеийн нийгэм-түүхийн нэг гол үйл явц болсон шинжлэх ухаан-техникийн дэвшил (ШУТД) нь нийгмийн амьдралын бүх талд нөлөөлөн улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах нэг чухал хөшүүрэг болохын зэрэгцээгээр эргээд түүний хөгжлийн тодорхой түвшингээр нөхцөлдөн тодорхойлогддог билээ. Улс орны социалист байгуулалт гүнзгийрэхийн хэрээр нийгмийн үйлдвэрлэлийн өмнө ШУТД тэй нягт холбоотойгоор шийдвэрлэвэл зохих өргөн цар хүрээтэй асуудал дэвшин гарч байгаа нь түүний хөгжлийн диалектик юм. В. И. Лениний зааж хэлсэнчлэн хамгийн шинэ шинжлэх ухааны сүүлчийн ололтууд дээр үндэслэн байгуулсан техникгүйгээр социализмын тухай сэтгэшгүй юм.¹

Тус орны социалист байгуулалтын цар хүрээ өргөжихийн хэрээр ШУТД нь нийгмийн амьдралын бүх салаа салбарт нэвтэрч тэдгээртэй улам бүр холбоо харилцаатай болж буй одоо үед нийгмийн хөгжлийн аливаа асуудлыг энэхүү дэвшлээс салгаж үзэхийн нөхцөлгүй юм. Энэ ч учраас МАХН-ын XIX их хурлаас «Шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглахтай холбогдолгүй шийдэх үйлдвэрлэлийн болон нийгмийн нэг ч асуудал байхгүй»² гэж онцлон заалаа.

МАХН-ын программ болон сүүлийн үеийн бусад баримт бичигт ШУТД-ийг цаашид өрнүүлэх үйл явцыг авч үзэхдээ шинжлэх ухаан техникийн болон нийгмийн хөгжлийн холбоо харилцаанаас урган гарч буй эл шаардлагыг гүнзгий тусгасан иж бүрэн зорилтууд дэвшүүлэн тавьсан юм. Шинжлэх ухаан-техникийн болон нийгмийн хөгжил, тэдгээрийн холбоо харилцааг шинжлэх ухааны үүднээс танин мэдэж, хөгжилд нь идэвхтэй нөлөөллийг үзүүлж, ухамсартай, чиглэсэн зорилготой гоор удирдан чиглүүлэх явдал ШУТД-ийн зүй тогтолт хандлага, түүний нийгэм-эдийн засгийн үр дагаврыг нарийвчлан судлахыг зүй ёсоор нөхцөлдүүлж байна. Энэ ч учраас одоо социалист орнууд, ялангуяа ЗХУ-д ШУТД-ийг хурдасгах нийгэм-эдийн засгийн асуудлуудыг судлан боловсруулах явдал нийгмийн шинжлэх ухааны судалгааны нэгэн